

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2023 ОНЫ 2 САРЫН 15-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын нэр:	Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал		
Огноо:	2023 оны 2 дугаар сарын 15-ны өдөр 11:00-13:00	Уулзалтын газар:	Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 1, Төв шуудангийн байр, 4 давхрын “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн хурлын заал
Хурлын дарга:	Содномдовжидын Нямбаяр, МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал		
Тооллогын комисс:	Дарга: Д.Ганцэцэг, Дотоод аудитын газрын мэргэжилтэн, Гишүүд: С.Цог, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн Б.Хулан, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер		
Ирц:	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,500,292 ширхэг саналын эрх бүхий 7 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.70441%		

Оролцсон хувьцаа эзэмшигчид:

Д/д	Хувьцаа эзэмшигч	Регистрийн дугаар	Хувьцааны тоо /ширхэг/
1.	Чулуунбатын Даваадолгор	ЙР78070405	50
2.	Энх-Амгалангийн Энхжаргал	ВЭ83120961	86
3.	Магсаржавын Отгонбаяр	ЧЙ65112711	500
4.	Мягмаржавын Шигшээ	ХБ74122819	4
5.	ТӨБЗГ	6098169	10,355,683
6.	Төрийн өмч	АА11111111	14,143,604
7.	Галт-Очирын Батнасан	УС74092001	15
8.	Довдонгийн Сумъяа	ЦГ43100909	350

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай

СОНССОН нь:

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээлэл 1. Компанийн тухай хуулийн 69.1-д заасан саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор 2.МЦХ ХК-ийн дүрмийн 7.12-д компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно гэж заасан заалтуудыг үндэслэн: Ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 24,500,292 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч ирж 94,70 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

С.Нямбаяр, хурлын дарга: Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 183 дугаар хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарласан байгаа. Ингээд хурал нээснийг мэдэгдье.

Хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулж, хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай

Хэлэлцэх асуудлаар нэмэлт хувьцаа гаргах тухай Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцууллаа.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай

Хэлэлцэх асуудлаар танилцуулгыг нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх талаар хууль, эрхзүйн үндэслэл, саналыг Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр танилцууллаа.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Бид “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өргөн сонголт бүхий үйлчилгээ үзүүлэгч, өрсөлдөх чадвараар салбартаа тэргүүлэгч компани байна.” гэсэн алсын хараатайгаар, “Харилцаа бүрийг холбоно.” гэсэн эрхэм зорилготой, “Холбоо хөгжлийн төлөө хамтдаа” уриа үгтэй, “Хэрэглэгчийн дээдлэл, Хамт олон, Хариуцлага, Брэнд нэр” гэсэн үнэт зүйлстэй. Бүтэц, зохион байгуулалтын хувьд Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, нийлэл орон нутгийн холбооны газрууд, нэг охин компанитай үйл ажиллагаа явуулж байна. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьд уламжлалт болон нэмэлтээр дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

Интернэт - ADSL технологи болон шилэн кабелийн интернэт, түрээсийн шугам, IP, домэйн хаяг., Суурин утас- NGN технологи, холбох & групп шугам, IP Centrex, 1800xxxx, 1900xxxx тусгай дугаар, Call center үйлчилгээ үзүүлээд явж байна. Бүх төрлийн мэдээллийн лавлах дуудлага үйлчилгээ маань явж байгаа. National TV кабелийн телевизийн үйлчилгээ үүнд TVROOM, OTT үйлчилгээ орж байна, мөн хяналтын камерын суурилуулалт, засвар үйлчилгээг “Эм ти си сервис” охин компани дээр хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлээд явж байна.

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаарх Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн судалгаа. Нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас ТӨБЗГ-24,499,287 ширхэг хувьцаа, нийт хувьцааны 94.7 хувийг эзэмшиж байгаа, 24 хуулийн этгээд, гадаадын 68 иргэн, дотоодын 3,908 иргэн хувьцаа эзэмшиж байна. Та бүхэнд тараасан материалд дээр хэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байгаа тоог үзүүлсэн байгаа.

Компанийн 2017-22 оны санхүүгийн үзүүлэлтээр 2017 онд 6 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2018 онд 316 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2019 онд 62 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2020

онд 43.4 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2021 онд 4.7 сая төгрөгийн цэвэр ашигтай, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр одоо санхүүгийн тайлан гадаад дуусаж байна, аудитлагдана. 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 8.1 сая төгрөгийн ашигтай байна гэсэн хүлээлттэй байна. Санхүүгийн харьцааны үзүүлэлтийг графикаар харуулсан байна.

Хувьцааны тоо бол өмнө харуулсан 25.9 сая ширхэг, хувьцааны ханш 2022 оны 12 сарын 01-ны өдрийн хаалтын ханшаар 502 төгрөг байсан, өчигдөр (2023.02.14) хаалтын ханш 690 төгрөг байна.

Згх зээлийн үнэлгээний хувьд 2017 онд 14.3 тэрбум төгрөг байсан боол 2022 оны байдлаар 13 тэрбум төгрөг байна. Арилжааны хувьд 52 долоо хоногт дээд ханш 752 төгрөг, доод ханш 480 төгрөг байсан.

Компани өнгөрсөн хугацаанд 18.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан байна. Нийт 20 удаа ногдол ашиг тарааснаас Монгол Улсын Засгийн газарт 10.2 тэрбум төгрөг, Корей телеком компанид 7.4 тэрбум төгрөг, бусад хувьцаа эзэмшигчдэд 993.8 сая төгрөгийн ногдол ашиг тус тус олгогджээ.

Компанийн давуу талын хувьд 100 жилийн туршлагатай, тогтвортой үйл ажиллагаа явуулсаар ирсэн, Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан үйлчилгээний өргөн сүлжээтэй. Орон нутагт 23 салбар нэгжтэй, төвөөс алслагдсан суурин газрын хүн амд харилцаа холбооны цогц үйлчилгээ үзүүлдэг 1994 онд ХК-ийн хэлбэрт шилжсэн төрийн оролцоотой компани байна. Сул талын хувьд техник, технологийн хоцрогдсон байна, Төрийн дэмжлэг, салбарын зохицуулалт дутмаг, Техникийн болон үйлчилгээний байр, талбай байхгүй, Мэдээлэл холбооны сүлжээ компаниас түрээслэн ашигладаг. Үндсэн үйл ажиллагаа нь МХС-аас шууд хамааралтай үйл ажиллагаа явуулж байна. Анх Мэдээлэл холбооны сүлжээ компани, Цахилгаан холбоо компаниудыг салгахад 4.4 тэрбум төгрөгийн урт хугацаат өглөг үүссэн нь одоог хүртэл шийдэгдээгүй явж байна. Сүүлийн үед хүний нөөцийн хомсдолд ихээр орж байгаа. Энд санхүүгийн хүндрэлүүд үүсэж байна. Гэхдээ бидэнд боломж байна гэж харж байгаа. Дэлхий даяараа болоод манай улсад мөн ижил цахим хэрэглээ нэмэгдсэн, төрөөс МХХТ-ийн салбарыг хөгжүүлэх бодлогын орчин сайжирсан, орон нутагт МХХТ-ийн салбарын үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, төрийн байгууллагын суурин утасны нэгдсэн сүлжээ байгуулах боломж байгаа. Аюулын хувьд суурин утасны хэрэглээ хумигдаж байгаа, инфляцын болон бүтээгдэхүүний ханшийн өсөлт бар тахал, онцгой байдлын үеийн нөхцөл байдал /хил гааль хаах, тээвэр саатах гэх мэт/ Салбарын өрсөлдөөн ихтэй олон компаниуд гарч байна. Технологийн хөгжлийн хурдтай байгаа ч хөрөнгө оруулалт өндөр өртөгтэй. Салбарын мэргэжлийн хүний нөөцийн дутагдал байгаа.

Хувьцаа нэмж гаргахаар ИХ хурлын 16 дугаар тогтоол гаргасан. Үүнд, 1. "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн өмчит банкны хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндсэн чиглэлд заасан хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, биржээр олон нийтэд нээлттэй худалдаж, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасугай." гэсэн тогтоол гарсан.

Үүнтэй холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол гарсан байгаа. Уг тогтоолд “1. Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг биржээр худалдахтай холбогдсон арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу авч хэрэгжүүлэх, шаардагдах эх үүсвэрийг тооцож, зохих ёсоор шийдвэрлэж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч болон Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай. 3. Төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн шууд хяналтад оруулах бодлогын хүрээнд энэ тогтоолын 1-д заасан хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр нь танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.

4. Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдахтай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 7-д заасан журмыг батлан мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөсүгэй.” гэсэн байгаа. Мөн, үүнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой тогтоол гаргасан. Энэ дээр хавсралтаар заагаад төрийн өмчит хуулийн этгээдүүдийн нэмэлт хувьцааг гаргах, хөрөнгийн биржээр арилжих, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид зөвлөсүгэй гэсэн ийм тогтоол гарсан.

Үүнтэй холбоотой сая төрийн мэдлийн компаниуд өнгөрсөн хугацаанд IPO хийж анхдагч зээл дээр гарсан. Төрийн банкнаас олон нийтэд санал болгосон үнэт цаасны хувь 5 хувь, нэгж хувьцааг олон нийтэд санал болгосон үнэ 590 төгрөг, төрийн банкны хөрөнгийн үнэлгээ 458 тэрбум төгрөг байсан. Монголын хөрөнгийн бирж оны өмнө гаргасан. МХБ-ийн олон нийтэд санал болгосон үнэт цаасны хувь, 34 хувь, нэгж хувьцааг олон нийтэд санал болгосон үнэ 100 төгрөг, МХБ компанийн хөрөнгийн үнэлгээ 26.1 тэрбум төгрөг байсан. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьд одоогийн байдлаар нээлттэй хувьцаат компани хэлбэрээр явж байгаа. Засгийн газрын оролцооны хувьд 94.7, бусад хувьцаа эзэмшигчид 5.3 хувийг эзэмшиж байгаа. Их хурал, Засгийн газрын 34 хүртэл хувийн нэмэлт хувьцаа гаргах гэсэн тогтоолтой холбоотой бид өнгөрсөн оноос бэлтгэл ажлыг хангаж байгаа. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж байгаа нь ч мөн үүнтэй холбоотой. Бидний төсөөлж байгаагаар Засгийн газрын оролцоог 66 хувь хүртэл бууруулах, үүнтэй адил бусад хувьцаа эзэмшигчдийн хувь 3.7 хувь руу бууж ирж байгаа. Шинэ хувьцаа эзэмшигчид 30.3 хувийн нэмэлт хувьцаа гаргаж хөрөнгө татан төвлөрүүлж гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Одоогийн тооцооллоор 11,250,000 ширхэг хувьцаа нэмж гаргах урьдчилсан төлөвлөгөөж байна. байгаа. Энэ нэмэлт хувьцаа гаргах талаар андеррайтерын компаниудыг сонгож ажиллуулах ёстой. Энэ дээр нэгж хувьцааны үнэ, тоо ширхэг тогтоох учраас үүнийг урьдчилсан байдлаар тооцоолсон. Бид нэмэлт хувьцаа гаргаж, нэмж хөрөнгө оруулалт хийж, техник технологи сайжруулсны дараагаар 2028 онд 23 тэрбум төгрөгийн орлоготой, 682 сая төгрөгийн ашигтай ажиллах урьдчилсан төлөвлөгөө гаргаад явж байна. 2024-28 он хүртэлх тооцооллыг хийж үзэхэд 24 онд цэвэр

ашгийг 449 сая төгрөг, 28 онд 682 сая төгрөг болгоод нийт цэвэр ашгийн 20 хувийг ногдол ашигт хуваарилбал 2028 онд нэгж хувьцаанд 3.6 төгрөг, 40 хувийг ногдол ашигт хуваарилбал нэгж хувьцаанд 7.3 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилах юм гэсэн тооцоолол байгаа.

Нэмж хувьцаа гаргаснаар давуу тал байгаа, үүнтэй адил эрсдэлүүд байгаа. Давуу тал бол үйлчилгээний чанар, төрөл сайжирна, техник технологийн найдвартай ажиллагаа хангагдана, түрээсийн зардал буурч цэвэр ашиг нэмэгдэнэ, хэрэглэгчдийн тоо нэмэгдэнэ, төр, жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийн хэмжээ нэмэгдэнэ, компанийн засаглал сайжирна гэж харж байгаа. Эрсдэлийн хувьд байр талбай түрээсээр эзэмшиж байгаа, компанийн урт хугацаат өр төлбөр байна, дэлхийн зах зээл дээрх технологийн компаниудын хувьцааны ханшийн уналт үргэлжилсээр байна, хөрөнгө оруулагчдыг татах брэнд үйлчилгээ бага байна, бид 2007 оноос түрээсийн байр ашигласнаар нийт 9.3 тэрбум төгрөгийг байр талбайн түрээсийн төлбөрт төлөөд байна, хөрөнгийн бирж дээр гарсан банкнууд болон бусад төрийн өмчит компаниудын биржид хувьцаа гаргах цаг хугацааны давхцал үүсэх магадлал байгаа, дотоодын санхүүжилтийн эх үүсвэр дутагдах, одоогийн арилжаа хийгдэж байгаа хувьцааны ханшаар компанийн зах зээлийн үнэлгээ бага байна гэж үзэж байгаа.

Дэлхийн зах дээр байгаа мэдээлэл, технологийн салбарын уналтын байдалтай байгаа мэдээллийг оруулж харьцуулсан байгаа.

Нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой одоогийн хуульд заасны дагуу дараах зардлууд компаниас гарахаар байна. Аудитын компанийн хөлс 30-100 сая төгрөг, хуулийн компанийн ажлын хөлс 20-100 сая төгрөг, үнэлгээний компанийн ажлын хөлс 10-100 сая төгрөг, андеррайтерын компанийн ажлын хөлс нийт босгосон хөрөнгийн 3-10 хүртэлх хувь, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний төлбөр төлнө. Монголын хөрөнгийн бирж дээр нэмэлт бүртгэлийн хураамж төлнө. Шинээр үнэт цаас бүртгэх бүртгэлийн хураамжийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд төлнө, арилжааны шимтгэл, бусад маркетингийн зардлууд гарна. Ингээд нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 5-7 хувь нь зардалд гарах нь байна гэж тооцож байна.

Мөн дараах хүндрэл бэрхшээлүүд байна. IPO хийсэн компаниудын анхдагч зах зээл дэх хувьцааны ханш биржийн хоёрдогч зах зээл дээр уналт үзүүлж байгаа нь ажиглагдаж байна; Ипотекийн зээлийн төлөлтийн чөлөөлөлтийн хугацаа дуусаж, 2023 оны 1 дүгээр сараас төлөлтүүд хийгдэж эхэлснээр биржийн арилжаанд оролцох дотоодын хөрөнгө оруулагчид буурах хандлагатай; Монголын хөрөнгийн бирж болон биржийн бус зах зээлд богино хугацаатай, өндөр хүүтэй бондуудын гаргаж буй давтамж ихэссэн; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29 дэх заалтын дагуу стратегийн хөрөнгө оруулагчтай хэлцэл хийх хувийг 5 хүртэл хувь дээр барьсан болохоор өндөр хэмжээнд стратегийн хөрөнгө оруулагч олох бололцоо үүсэхгүй байгаад байна; Одоо эхний хагас жилд багтаж системийн нөлөө бүхий Худалдаа хөгжил, Хаан, Хас банкны IPO хөрөнгийн бирж дээр гарах, төрийн өмчит компаниудын 34 хүртэлх хувийг биржээр арилжаалах ажлууд 2023 оны эхний хагас жилд хийгдэхээр байгаа. Бид 2023 оны эхний хагас жилд бирж дээр гарах юм бол хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхэд хүндрэл үүсэх юм гэж үзсэн. Гадаад хүчин зүйлсийн хувьд: 2022 онд гадаад зах зээл дээрх хувьцааны ханшийн уналт өндөр хувьтай байгаа. TheGlobalEconomy-ийн мэдээлж буйгаар дэлхийн 186 орны дундаж инфляцын түвшин 15.7 хувь буюу өмнөх оноос 6.6 хувиар өссөн. Дэлхийн улс орны төв банкнууд инфляцыг барихын тулд мөнгөний бодлогоо чангатгаж, цар тахлын хүнд үеийг туулахдаа хэдэн их

наяд ам.доллороор нь хэвлүүлсэн мөнгөн дэвсгэртүүдээ зах зээлээс буцаан татах оролдлогууд хийж байна. Мөн дайнтай холбоотой хүндрэлүүд үүсэж байгаа. Дэлхийн томоохон үйлдвэрлэгч орон болох БНХАУ-д цар тахлын аюул бүрэн гүйцэд арилаагүй байгаа нь тоног төхөөрөмж бусад манайтай холбоотой асуудаар хүндрэл үүсгэж байгаа. Таваарын бүтээгдэхүүнүүдийн ханш өсөл нөлөөлж байна.

Бид Их хурал, Засгийн газрын тогтоолыг биелүүлэх үүднээс тодорхой төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарласан, өнөөдөр ингээд хуралдаж байна. Хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээд хөрөнгийн дахин үнэлгээ хийж авсан. Мэдээлэл холбооны сүлжээ компанитай урт хугацааны өглөгийг шийдвэрлэх талаар хоёр компани харилцан яриа, хэлэлцээр хийгдээд явж байна. Андеррайтер компаниудтай эхний байдлаар уулзаад санал солилцоод явж байна. Мөн зөвлөх үйлчилгээний компаниудтай уулзаад зөвлөгөөгөө аваад явж байгаа. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар урьдчилсан байдлаар төлөвлөөд байгаа. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох, тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай асуудлыг эцэслэн шийдвэрлэх асуудал өнөөдрийн хурлаар шийдэгдээд явна. Нэмж хувьцаа гаргах асуудлаар холбогдох байгууллагуудад хандсанаар өнгөрсөн долоо хоногийг Засгийн газрын хурлаар хэлэлцэж манай асуудлыг энэ оны 4-р улирал хүртэл хойшлуулсан тогтоол гарсан байгаа.

С.Нямбаяр, хурлын дарга: Эхний хэлэлцэх асуудлын танилцуулга дууслаа. Хоёр дугаар хэлэлцэх асуудал нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх талаар хууль, эрхзүйн үндэслэл, саналыг Хууль гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр танилцуулна.

Ж.Азбаяр, ХГХА-ны ерөнхий менежер: Энэ хэлэлцэж байгаа асуудлаар бид Санхүүгийн зохицуулах хороонд хандаад тодорхой чиглэл авсан байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 01 сарын 17-ны өдрийн 9/167 тоот албан бичгээр чиглэл ирүүлсэн. Энэ чиглэлд “Компанийн тухай хуулийн 34.2 дахь хэсэг, 38-р зүйлд заасны дагуу нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид нэмж авах заалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй” гэсэн. Энэ асуудлыг Компанийн тухай хуулийн болон Компанийн дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудал байгаа.

Өнөөдөр энэ асуудлыг бид бүхэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр байгаа. Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-т Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар компаниас нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах үндсэн эрх бол хувьцаа эзэмшигчид байна. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд: Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй холбоотой заалт байна. 38.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй. Гэж заасан. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалт, сая танилцуулсан Санхүүгийн зохицуулах хорооны чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлагын зүгээс нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлбэ гэдэг саналыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байна. Ийм учраас өнөөдрийн энэ хурлаар та бүхнийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж хүсэж байна.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлж байгаа хоёр асуудлын тогтоолын төслийг танилцуулъя. (Хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг уншиж танилцуулав.)

С.Нямбаяр, хурлын дарга: За, хоёр дахь хэлэлцэх асуудлын танилцуулга дууслаа. Хурлаар хэлэлцэж байгаа хоёр асуудалтай холбоотой асуулт, санал байгаа юу?

Асуулт хариулт, санал:

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Нэгж хувьцааны үнэ хэдэн төгрөг гэж байгаа вэ?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Нэгж хувьцааны үнийг одоогоор тогтоогоогүй. Хуулиар СЗХ-ны хорин нэгэн андеррайтерын компаниас сонгон шалгаруулалт, гэрээ хийгээд андеррайтерын компани ажилласны дараагаар нэгж хувьцааны үнэ болоод тоо ширхгийг гаргаж ирнэ. Гол хүлээгдэж байгаа зүйл бол санхүүгийн тайлан, аудитлагдсан тайлан гарсны дараа андеррайтерын компанид бүх баримтуудаа өгнө. Андеррайтерын компани чамгүй урт хугацаанд судлах юм билээ. Санхүү, үйл ажиллагаа, зах зээлээ судлаад тэгсний дараа нэгж үнийг тогтоох юм билээ. Бид андеррайтерын компанитай ажиллаж тоо ширхэг, үнийн саналыг гаргаж дахин хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж саналаа батлуулна.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Хувьчлалыг 4 дүгээр улиралд хийхээр боллоо гэж ярилаа. 10, 11 сард гэсэн үг үү.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Тийм, 10, 11, 12 сарын аль нэгэнд, 4-р улиралд багтаж.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Тэргүүн ээлжид худалдах авах тухайн Хувьцаа эзэмшигч нь хувьцаа худалдаж авах тоо ширхэг нь тухайн үед эзэмшиж байгаа үед байгаа хувьцааны тоо ширхгээр нь хувь тэнцүүлж авах юм уу.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Тийм.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Яг өнөөдрийн эзэмшиж байгаа хувьцааны тоогоороо хувь тэнцүүлж авах юм уу. би өнөөдөр 500 ширхэг хувьцаа эзэмшиж байна. Тэгэхээр эхний ээлжид худалдан авахдаа 500-г авах юм уу, аль эсвэл 4 дүгээр улирал болтол 600, 700 болгочихвол яах билээ?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Та, нэмээд 1500 ч юм уу хувьцаатай болчихвол гээд байна уу. Яг бирж дээр гарахад та хэдэн ширхэг хувьцаа эзэмшиж байна түүнийхээ хувиар болно. Өнөөдрийн байдлаар биш.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Нэг ширхэг хувьцааны үнийг тогтоогоогүй байгаа гэсэн. Тийм ээ?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Тогтоогоогүй.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Нэмэлт IPO хийж хөрөнгө татан төвлөрүүлэх гээд байгаа биз дээ.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Хаалттай байж байгаад Төрийн банз гэдэг ч юм шиг хувьцаат компани болж байгаа тэдний хувьд IPO, бидний хувьд нээлттэй хувьцаат компани, хувьцаа эзэмшигчдтэй бидний хувьд нэмэлт хувьцаа гаргана. Бид одоо байгаа 25.8 сая хувьцаа дээрээ нэмж хувьцаа гаргана гэсэн үг.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Тэгэхээр төрийн эзэмшлийн хувьцааны хувь буурах юм уу?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Тийм, буурна. Засгийн газар 66.0 хувь, бусад хувьцаа эзэмшигч 3.7 хувь болж буурна. Одоо засгийн газар 94.7 хувь буюу 24,499,287 ширхгийг эзэмшдэг, бусад хувьцаа эзэмшигчид 5.3 хувь нийт хувьцаа нь 1,370,989 ширхэг. Бид Засгийн газрын хувийг 66 хувьд буулгаад, одоогийн бидний тооцооллоор 11,250,000 ширхэг хувьцааг нэмж гаргахад Засгийн газрын хувь 66 хувь руу, бусад хувьцаа эзэмшигчдийн хувь 3.7 хувь руу бууж ирнэ. Тэгээд тэр зөрүү 30.3 % хувь дээрээ нэмэлт хувьцаа эзэмшигчид орж ирнэ гэсэн үг.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Тэгээд тэр нь ямар давуу талтай вэ, Аль аль талдаа санхүүгийн хувьд шилэн болох юм уу, засаглалын хувьд нээлттэй байж чадах уу?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Засгийн газрын оролцоо буурна, бусад хувьцаа эзэмшигчид хувь хүртэх, бирж дээр арилжаалах тоо ширхэг нэмэгдэж байгаа учраас бүхий л талаараа ач холбогдолтой.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Нээлттэй байж чадах уу л гээд байхгүй юу.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Одоо ч нээлттэй байгаа.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Засгийн газрын оролцоо нь илүү өндөр байгаа. Хүмүүс ирсэн ч ирээгүй ч түүгээрээ гарчихна. Тэгэхээр нэмж хувьцаа гаргаснаар жижиг хувьцаа эзэмшигчдэд ямар ашигтай вэ?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Засгийн газрын оролцоо 66 хувь руу буураад ирэхээр бусад хувьцаа эзэмшигчдийн оролцооны хувь нэмэгдэнэ.

Төрийн өмчийн төлөөлөл, (Ц.Шинэхүү): Би хариулт хэлье. Засгийн газар одоо 94.7 хувийг эзэмшиж байгаа. Төрийн эзэмшлийн хувийг 66 хувь болгоод буулгаж байна. Тэгэхээр бусад хувьцаа эзэмшигчид 34 хувийг эзэмших гээд байна. Таны хэлэх гээд байгаа санаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн санал шийдвэрт тусахгүй байгаа.

Одоо 34 хувь гэдэг чинь хяналтын багц болж байгаа. Тэгэхээр та бүхний санал нөлөөлж эхэлнэ. Засгийн газар 94 хувь эзэмшиж байгаа үед саналыг сонсоод л батлах үедээ та бүхний саналыг тусгахгүй байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл гээд 6 хүн сууж байна. 66, 34 хувь гэсэн харьцаатай болчихвол 34 хувь эзэмшиж байгаа этгээдээс Төлөөлөн удирдах зөвлөлд хоёр гишүүн орох эрх нээгдэж байгаа. Хэдийгээр 5.3 хувь нь 3.7 хувь болж байгаа ч гэсэн төрийн эзэмшлийн хувь нь нээлттэй болж байгаа. Хувьцаа эзэмшигчдийн тоо тодорхой хувиар нэмэгдэнэ. Та бүгдийн саналыг сонсдог болно гэсэн үг. ТУЗ-д хэнийг томилохоо сонгодог болно.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Энэ чинь хэдэн ширхэг хувьцаа байгаа вэ?

Б.Чинбат, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: 5.3 хувь маань 3.7 руу буугаад, шинээр 30.3 хувь буюу 11,250,000 ширхэг хувьцаа нэмэлтээр гаргана гэсэн үг.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Хавар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болно гэж байна шдээ, тэрүүгээр дахин яригдах нь ээ дээ?

Б.Чинбат, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Дөрвөн сард ээлжит хурал болдгоороо болно. Бид амжуулахын төлөө ажиллана. Гэрдээ андеррайтерын компаниас шалтгаалах болохоор амжихгүй байх магадлалтай. Хэзээ хувьцааны үнэ, тоо ширхгийн мэдээлэл

тодорхой болно тэр үед нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулж шийдвэрлэнэ. Амжвал хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа зарлаад хуралдуулах боломжтой.

Т.Гандулам, Хөрөнгө оруулалтын зөвлөх: Нэг зүйлийг тодруулахад, Компанийн хууль, компанийн дүрмээр энд хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдахаар боллоо гэхэд энэ хүмүүст боломж олгож байгаа. Та одоо байгаа хувьцаа дээрээ нэмээд хувьцаа худалдаж авч болно. Энэ маань процессын хувьд ажлын 30 хоног байдаг. Амралтын өдрүүд хасагдаад явахаар бараг хоёр сар болдог. Эхлээд одоо байгаа хувьцаа эзэмшигчдээ эзэмшүүлээд үлдсэнийг нь шинэ хувьцаа эзэмшигчдэд санал болгодог. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах гэж энэ зохицуулалтыг хийж байгаа учраас хуулиараа ажлын 30 хоног нэлээн процессын ажил хийгддэг. Тэр ажил нь 3 сарын 20-ноос тайлан гараад явахаар илүү удаашрах төлөвтэй байгаа. Тиймээс хуулийн хугацаатай, хугацаанд шахагдаад хойшилж байгаа.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Би сайн ойлгосонгүй. Сая ингэж ярилаа шдээ, гуч аравны хэдэн хувь гээд нийт нэмж гаргах хувьцааны тоо хэллээ. Тэрийг шинээр хувьцаа эзэмшигчдэд зарах юм уу?

Т.Гандулам, Хөрөнгө оруулалтын зөвлөх: 30.3 хувийг одоо байгаа 5.3 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нарт эхлээд санал болгоно. Та өөрийн байгаа хувь хэмжээгээ тэр хувиар нь нэмэгдүүлж авч болно. Бүгдийг нь авна гэвэл 5.3 хувь чинь 10.6 хувь болох байхгүй юу. Тэгвэл 30.3 хувиас 10.6 хувийг хасаад үлдсэнийг нь шинэ хувьцаа эзэмшигчдэд санал болгоно гэсэн үг.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Жижиг хувьцаа эзэмшигчдэд давуу эрх олгож байна. Худалдах авах боломжоо хэзээ олгох вэ?

Т.Гандулам, Хөрөнгө оруулалтын зөвлөх: Нэмж хувьцаа гаргах зөвшөөрөл өнөөдрөөс эхэлж байна. ТУЗ-д эрх өгч байна, тэгэхээр андеррайтер компани сонгоно. Андеррайтерын компани prospectus гээд танилцуулга бэлдэх ёстой. Үүнийг гаргахдаа нэмж гаргаж байгаа хувьцааны үнийг зах зээлийн үнээр тогтоох юм уу, бизнесийн үнээр тогтоох уу, өртгөөр тогтоох юм уу гээд 3 төрийн аргаар алинаар нь тогтоох вэ гэдэг шийдвэрүүдээ гаргаад хөндлөнгийн үнэлгээний компани үнэлгээ тогтооно, хуулийн дүгнэлт орж ирнэ гээд олон процесс явагддаг. Анх IPO гаргахтай бараг адил ажиллагаа явагдана. Түүний дараа үнэ тогтоогдоод ахиад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ч юм уу хуралдаад яг нэгж хувьцааг ийм үнээр та бүхэнд нэмэлт хувьцаа гаргах гэж байна. Та энэ үнээр худалдаж авах уу гээд санал авна.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: Тэгэхээр хэдэн ч төгрөгийн хувьцаа худалдаж авч болно гэсэн үг үү.

Т.Гандулам, Хөрөнгө оруулалтын зөвлөх: Үгүй. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлагдана. Тухайн ээлжит бус хурлаар үнэ тогтооно. 500 төгрөг үү, 600 төгрөг байх уу гээд орж шийдвэр нь гарах юм. Тэр үед та бүртгэх өдрөөр тасалбар болоод өнөөдрийнх шиг цуглах нь байна шдээ. Тэр бүртгэх өдрөөр байгаа хувьцааны тоо, ширхгээр таны авах эрх үүснэ гэсэн үг. Тэр үед та хувьцаагаа нэмж болно, хасаж болно.

М.Шигшээ, хувьцаа эзэмшигч: За за. Ойлголоо.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Энд нэг тоо байна. Нэг хүн 52 мянган ширхэг хувьцаа эзэмшигдэг гэж байна. Энэ үнэн үү?

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Үнэн.

М.Отгонбаяр, хувьцаа эзэмшигч: Гадаадын иргэнд нэг хүн тавин хоёр мянга, гурван зуун арван таван ширхэг хувьцаа эзэмшдэг гэж гарсан байна.

Ж.Баасандорж, СБААГ-ын захирал: Энэ бид нараас гарч байгаа судалгаа биш. Бирж дээр бүртгэгдсэн мэдээг албан ёсоор хүлээн авч, боловсруулалт хийж үзүүлсэн байгаа.

С.Нямбаяр, хурлын дарга: За, өөр асуулт байна уу?

Асуулт, хариулт, саналыг үүгээр дуусгая. Одоо Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар санал хураалтаа эхлүүлье. Та бүхэнд саналын хуудас тараасан байгаа. Хоёр хэсэгтэй, хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудаар зөвшөөрсөн, татгалзсан гэсэн хоёрхон хариулт сонгоно. Татгалзсан тохиолдолд өгөх саналаа гараараа бичиж өгнө нэг дэх хэсэг маань, хоёр дахь хэсэг нь хувьцаа эзэмшигч та бүхний бөглөх хэсэг байгаа. овог нэр, регистр, гарын үсгээ бүрэн бөглөх шаардлагатай. Тэгж байж та бүхний санал хүчинтэйд тооцогдоно. Ингээд 5 минутын хугацаанд Тооллогын комисс санал хураалтаа явуулъя.

С.Нямбаяр, хурлын дарга: Санал өгч дууссаны дараа хурлын завсарлага буюу тооллогын комисс маань дүнгээ гаргах хүртэл 15 минут завсарлана.

С.Нямбаяр, хурлын дарга: Хурлын завсарлага дууссан байна. Хурлаар хэлэлцэх асуудлаар тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж гарсан байна. Одоо тооллогын комиссын тогтоолыг тооллогын комиссын дарга Ганцэцэг танилцуулна.

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: *(Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.)* Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 1 дүгээр асуудлыг 100% (хувь)-ийн саналаар, 2 дугаар асуудлыг 100% (хувь)-ийн саналаар тус тус батлах нь зүйтэй гэж үзсүгэй.

С.Нямбаяр, хурлын дарга: 2023 оны 2 сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр, тогтоолыг уншиж танилцуулъя. *(Хурлаас гарсан тогтоолыг уншиж танилцуулан, хурлыг хаав).*

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 24,500,292 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 7 саналын хуудас хүчинтэй, 0 саналын хуудас хүчингүй байна.

Саналын хуудсанд 2 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн хувьцааг нэмж гаргах эсэх тухай асуудлаар:

Зөвшөөрсөн 7 санал, 100 хувиар буюу	24,500,292 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу	0 ширхэг хувьцаа

2. Компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх асуудлаар:

Зөвшөөрсөн 7 санал, 100 хувиар буюу	24,500,292 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу	0 ширхэг хувьцаа

ШИЙДВЭРЛЭСЭН нь:


1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Компанийн энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрөв.
 - б. Компанийн нэмж гаргах энгийн хувьцааны тоо ширхэг, нэгж үнийг компанийн 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайланд үндэслэн хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, саналаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Лхагвасүрэн)-д даалгав.
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.
 - б. Нэмж гаргаж буй энгийн хувьцааны нэгж үнийг тогтоосны дараа хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлэх ажлыг холбогдох хууль, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Лхагвасүрэн)-д үүрэг болгов.

ТАНИЛЦСАН:



С.НЯМБАЯР, ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2023 оны 2 дугаар сарын 16
Улаанбаатар хот.